

UCS 1901B:2020


ГЭРЭЛТҮҮЛЭГ, ГЭРЛЭН ЧИМЭГЛЭЛ



Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд
байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид
тавигдах шаардлага

ГЭРЭЛТҮҮЛЭГ, ГЭРЛЭН ЧИМЭГЛЭЛ

Нийтийн эзэмшлийн гудамж, зам,
талбайд байршуулах гэрэлтүүлгийн
тоног төхөөрөмжид тавигдах шаардлага



ГАРЧИГ

1. ЗОРИЛГО	3
2. ХАМРАХ ХҮРЭЭ	3
3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ	3
4. НОРМАТИВ ЭШЛЭЛ	4
5. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ	4
6. ГЭРЭЛТҮҮЛГИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
7. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	6
8. ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТӨРӨЛ АНГИЛАЛ	7
9. ГЭРЛИЙН БҮРХҮҮЛИЙН ЗАГВАР	10
10. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ГАН ШОНГИЙН ӨНГӨ	10
11. ГЭРЛИЙН ӨНГӨ	11
12. БАЙРЛУУЛАХ УДИРДАМЖ	11
13. СУУРИЛУУЛАХ ТЕХНИК	13
14. АШИГЛАЛТ	15
15. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	16

ХОТЫН СТАНДАРТ

ГЭРЭЛТҮҮЛЭГ



- Ерөнхий шаардлага
- Гэрэлтүүлэгчийн ангилал
- Гэрэлтүүлгийн толгойны ангилал
- Гэрэлтүүлгийн шонгийн ангилал
- Гэрлийн өнгө
- Байрлуулах удирдамж
- Суурилуулах техник
- Ашиглалт

1. ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү баримт бичгийн зорилго нь хувийн хэвшлийн байгууллагуудын нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн зураг төсөл боловсруулах болон барилгын ажил гүйцэтгэх үйл ажиллагаанд нэгдсэн арга зүйн удирдамж өгч, хотын оршин суугчдын эрүүл ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү баримт бичгийг нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн зураг төсөл боловсруулах болон барилгын ажил гүйцэтгэж байгаа захиалагч, барилгын зураг төсөл зохиогч, барилгын ажлын гүйцэтгэгч, иргэн, аж ахуйн нэгж, энэ чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллага дагаж мөрдөнө.

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1 **Гадна орчны гэрэлтүүлэг** - гэж харанхуй үед гудамж, замаар зорчигчийн зорчих хэсэгт хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй, тав тухтай зорчих нөхцөлийг хангах зориулалттай байнгын суурин гэрэлтүүлгийг;
- 3.2 **Гэрлийн чадал** - гэж гэрэл үүсгүүрээс нэгж хугацаанд цацаргах энергийн тоо хэмжээг хэлнэ. Чадлыг Ватт /Вт/ -аар хэмжинэ;
- 3.3 **Гэрлийн урсгал** - гэж хүний нүдэнд гэрэл болж харагдах цацралын энергийн чадлын хэсгийг хэлнэ. Гэрлийн урсгалыг Люмен /лм/ -ээр хэмжинэ;
- 3.4 **Гэрэлтэлт** - гэж гэрэлтүүлэгдэж буй гадаргуу дээрх гэрлийн урсгалын нягтын тоон үзүүлэлтийг хэлнэ. Гэрэлтэлтийг Люкс /лк/ -ээр хэмжинэ;
- 3.5 **Гэрлийн тодрол** - гэж гэрэлтүүлэгдэж буй гадаргуугаас хүний харааны зүгт чиглэсэн гэрлийн хүчийг тэр гадаргуун талбайд харьцуулсан харьцааг хэлнэ;
- 3.6 **Гэрлийн өнгө** - гэж гэрлийн долгионы уртаас шалтгаалан гэрэл өөр өөр өнгө үзүүлэх бөгөөд үүнийг гэрлийн өнгөний температураар илэрхийлж Кельвин /К/ -ээр хэмжинэ;
- 3.7 **Гэрлийн бохирдол** – гэж зохиомол гэрэлтүүлгийг үр ашиггүйгээр хэт их ашиглахыг;


4. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигтэй хамт дараах Монгол улсын үндэсний стандарт /MNS/, барилгын норм ба дүрэм /БНБД/ баримт бичгүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- 4.1 БД 43-101-03; "Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм"
- 4.2 БД 30-102-11; "Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх"
- 4.3 БНБД 23-02-08; "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг"
- 4.4 БНБД 83-27-00; "Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг"
- 4.5 MNS 2568:1983; "Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага"

5. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ

5.1 Гудамжны гэрэлтүүлгийн төхөөрөмжийн бүтэц нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.



Зураг 5.1. Гэрэлтүүлгийн бүтэц

6. ГЭРЭЛТҮҮЛГИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэгт гэрэлтэлт, гэрлийн толгой, шонгийн үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг гэрэлтүүлгийг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 6.1) -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 6.1. Гэрэлтүүлгийг хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гэрэлтүүлгийг зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гэрэлтүүлэг зургийн дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Гэрэлтүүлэг нь гудамж, зам, талбайн ангилалд тохирсон загвар дизайнтай байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гэрэлтүүлгийн шон дээрх дугаарлалт тод харагдахуйц байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гэрэлтүүлгийн төхөөрөмж нь эдийн засгийн хувьд үр ашигтай эрчим хүчний хэмнэлттэй байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гэрэлтүүлгийн гэрэлтэлт нь батлагдсан нормыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Гэрэлтүүлгийн металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Гэрэлтүүлгийн шон дээрх цахилгаан холболтыг бөглөсөн таг нь цоожтой хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Гэрэлтүүлгийн шон дээрээс холбооны утас болон зориулалтын бус бусад кабель утас байршуулаагүй байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Гэрэлтүүлгийн шон нь байгаль цаг уурын сөрөг нөлөөлөлд тэсвэртэй болохыг гэрчилсэн сертификаттай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Тухайн хэсэгт ашиглагдаж байгаа гэрэлтүүлгийн нэг төрөл, жигд байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Гэрэлтүүлгийн удирдлагын самбар нь Шуурхай удирдлагын зохицуулалтын төвөөс удирдаж хэвийн ажиллаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

7. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1 Гудамжны гэрэлтүүлэг нь хот суурин газрын дүр төрхөд ихээхэн нөлөөлдөг учраас зураг төсөл гүйцэтгэхээс эхлүүлэн архитектур дизайны үзэл баримтлалтайгаар төлөвлөх ёстой.
- 7.2 Гудамжны гэрэлтүүлэг нь шөнийн цагаар замын хөдөлгөөний ослын эрсдэлийг бууруулах, гэмт хэргийг таслан зогсоох, барилга, эд хөрөнгийг хамгаалах, орон байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зэрэг чухал үүрэг гүйцэтгэдэг.
- 7.3 Хотын түүхэн ач холбогдолтой онцлог гудамж, зам, цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд гудамжны гэрэлтүүлгийн дизайн, суурилуулалтын гоо зүйн чанарт онцгой анхаарал хандуулах шаардлагатай.
- 7.4 Хотын авто зам, гудамж талбайн гэрэлтүүлэг нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан, дэвшилтэт технологийг ашигласан, эдийн засгийн үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй, хүрээлэн орчинд сөрөг нөлөөгүй, засварлахад хялбар байх зарчимд нийцсэн байна.
- 7.5 Гудамжны гэрэлтүүлгийг гудамж замын чиг үүргийг тодорхойлох, хотын дизайны эффекийг бий болгоход ашигладаг бөгөөд гэрэлтүүлгийг төлөвлөхдөө гудамжны нөхцөлд тохируулан үр ашигтай байх гэрэлтүүлгийн төрлийг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд ялангуяа хотын хөдөлгөөний эрчим багатай хэсэгт гэрлийн бохирдол үүсгэхгүй байх нөхцөлийг анхаарах нь чухал.
- 7.6 Замын хөдөлгөөнд оролцогч жолооч, унадаг дугуй, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс гудамжны бүх хэсэгт гэрэлтүүлэг сайтай байх ёстой. Хотын гудамж, зам ба талбай, цэцэрлэгт гудамж, талбар, явган зорчих гудамж бичил хорооллын зорчдоггүй хэсгийн гэрэлтэлтийн шаардлагыг “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08”-д заасны дагуу төлөвлөж гүйцэтгэнэ.
- 7.7 Гэрэлтүүлгийн шон, гэрэлтүүлэгч, нарны зай болон бусад холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт шаардлага хангасан байх ёстой бөгөөд гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 7.8 Гэрэлтүүлгийн шонг суурилуулахдаа гудамжны ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах шаардлагатай.
- 7.9 Гудамжны архитектур, гоо зүйг бий болгох үүднээс гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, толгой, хүзүү нь гудамжны бусад тавилгатай өнгө, загвар, дизайны уялдаатай, нэгдсэн хослол байх.
- 7.10 Гэрэлтүүлгийн төхөөрөмж нь байгаль цаг уурын нөлөөлөл ус, тоос шороо нэвтрэхгүйгээр битүүмжилсэн байх.
- 7.11 Гэрлийн бүрхүүл хэсгийн дотоод температур 100°C-ээс хэтрэхгүй байх.
- 7.12 Гэрэлтүүлгийн шон нь Монгол улсын үндэсний стандарт Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага MNS2568:1983 -ийн шаардлага хангасан байх.
- 7.13 Гэрэлтүүлгийн шонгийн ашиглалт 20-30 жил байна.
- 7.14 Гэрэлтүүлгийн шонгийн ханын зузаан 3.5 мм-ээс багагүй байна.
- 7.15 Гэрэлтүүлгийн эрчим хүчний тэжээлийн хуваарилах самбар нь алсын зайн нэгдсэн удирдлагаар удирдагдахад зориулагдсан бүтэц тоноглолтой байна.

8. ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТӨРӨЛ АНГИЛАЛ

- 8.1 Гэрэлтүүлгийн шон нь Монгол улсын үндэсний стандарт MNS2568:1983-ийн гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд шонг өндрөөр нь дараах байдалтай ангилна. Үүнд:

Хүснэгт 8.1. Шонгийн өндрийн хамруулсан ангилал

№	Гэрэлтүүлгийн шонгийн нэр	Хэмжээ /метр/
1	Өндөр шон	15 – 40
2	Дундаж өндөртэй шон	12 – 15
3	Авто замын гэрлийн шон	6 – 12
4	Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрлийн шон	2.5 – 5
5	Зүлэг ногоон байгууламжийн шон	0.6 – 0.8

- 8.2 Гэрэлтүүлгийн шон нь байгаль цаг уурын нөлөөлөл, зэврэлтээс хамгаалагдсан байх ёстой бөгөөд шонг хийгдсэн материалаар нь дараах байдалтай ангилна. Үүнд:

Хүснэгт 8.2. Ган шонгийн материалын ангилал

№	Гэрэлтүүлгийн ган шонгийн нэр	Тайлбар
1	Цайрдсан төмөр	BS EN ISO1461
2	Төмөр	Стандартын дагуу будсан байх
3	Цайрдсан ган	BS EN ISO1461
4	Зэвэрдэггүй ган	-

- 8.2 Гэрэлтүүлгийг хотын тохижилт, гудамжны гэрэлтүүлгийн бусад хүчин зүйлүүдтэй уялдуулан ашигладаг бөгөөд зонхилон ашиглаж байгаа зургаан гэрлийн эх үүсвэр нь дараах байдалтай ангилна. Үүнд:

А. Төмөр галидын гэрэл - Metal Halide



Чадал: 70Вт, 100Вт, 150Вт
 Гэрлийн өнгө: 3200К, 4200К, 5600К
 Ажиллах дундаж хугацаа: 10'000 цаг

В. Өндөр даралтын натрын гэрэл - High Pressure Sodium (HPS)



Чадал: 70Вт, 100Вт, 150Вт,
250Вт, 400Вт, 600Вт, 1000Вт
Гэрлийн өнгө: 2000К
Ажиллах дундаж хугацаа:
20'000 цаг


С. Бага даралтын натрын гэрэл - Low Pressure Sodium (LPS)



Чадал: 35Вт-180Вт
Гэрлийн өнгө: 1700К
Ажиллах дундаж хугацаа:
18'000 цаг

Д. Харас дамжуулагч Лед гэрэл - Light Emitting Diode (LED)

а. Модулагдчилсан лед гэрэл - Modular led light



Чадал: 35Вт-250Вт
Гэрлийн өнгө: 2700К,
3000К, 3500, 4100К, 5000К,
6000К
Ажиллах дундаж хугацаа:
50'000 цаг

б. Коб лед гэрэл - Cob led light



Чадал: 35Вт-250Вт
Гэрлийн өнгө: 2700К,
3000К, 3500, 4100К, 5000К,
6000К
Ажиллах дундаж хугацаа:
50'000 цаг

с. Хавтгай самбарт лед гэрэл - Flat-panel integrated led



Чадал: 35Вт-250Вт
 Гэрлийн өнгө: 2700К,
 3000К, 3500, 4100К,
 5000К, 6000К
 Ажиллах дундаж
 хугацаа: 50'000 цаг

Е. Фосфорын шар лед гэрэл - Phosphor-Converted Amber (PCA) LED



Чадал: 35Вт-250Вт
 Гэрлийн өнгө: 2700К,
 3000К, 3500К, 5000К
 Ажиллах дундаж хугацаа:
 50'000 цаг


F. Нарийн ширхэгт шар лед гэрэл - Narrow-Band Amber (NBA) LED



Чадал: 20Вт-200Вт
 Гэрлийн өнгө: 2700К,
 3000К, 3500,
 Ажиллах дундаж хугацаа:
 50'000 цаг

8.4 Гэрэлтүүлгийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээс нь хамааруулан дараах байдалтай ангилна. Үүнд:

- А. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй
- В. Төвийн нэгдсэн эрчим хүчний эх үүсвэртэй



9. ГЭРЛИЙН БҮРХҮҮЛИЙН ЗАГВАР

Домус / Domus 	Дусал / Teardrop 	Дөрвөлжин / Shoebox 
Дэнлүү / Lantern 	Боргоцой / Acorn 	Орчин цагийн / Contemporary 
Модерн / Modern 	Могойн толгой / Cobra 	Hydra 






Зураг 9.1. Гэрлийн бүрхүүлийн загвар

10. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ГАН ШОНГИЙН ӨНГӨ

10.1 Хотын гэрэлтүүлгийн шон нь зэвэрдэггүй ган, цайрдсан ган болон цайрдсан төмөр материалтай байх бөгөөд будагтай төмөр шон ашиглах тохиолдолд Хүснэгт 10.1-д заасан өнгийг ашиглана.

10.2 Хотын гудамж, зам, талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн шон тухай байршилд нэг төрөл байх нөхцөлийг хангах ёстой бөгөөд олон өнгө хольж ашиглахыг хориглоно.

Хүснэгт 10.1. Гэрэлтүүлгийн шонгийн өнгө

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код
2	Хар RAL RAL 9011 /#00694c/		RGB: 39, 41, 43
2	Ногоон RAL 6016 /#00694c/		RGB: 0, 158, 76
3	Саарал RAL 7035 /#c5c7c4/		RGB: 197, 199, 196
4	Зэвэрдэггүй ган		
5	Цайрдсан төмөр		

11. ГЭРЛИЙН ӨНГӨ


11.1 Гудамжны гэрэлтүүлэгт ашигладаг цайвар өнгө нь хамгийн түгээмэл ашиглагддаг шар өнгийн, шаргал болон цагаан өнгөний хооронд хэлбэлздэг бөгөөд 3000K -аас 5000K /Кельвин/ хүртэлх өнгөний температуртай гэрлийг сонгож хэрэглэнэ.



Зураг 11.1. Гэрлийн өнгөний температурын ангилал

12. БАЙРЛУУЛАХ УДИРДАМЖ

- 12.1 Гэрэлтүүлгийн шон, гэрэлтүүлэгч, нарны зай болон бусад холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт шаардлага хангасан байх ёстой бөгөөд гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 12.2 Гэрэлтүүлгийн шонг суурилуулахдаа гудамжны ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах шаардлагатай.
- 12.3 Гудамжны архитектур, гоо зүйг бий болгох үүднээс гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, толгой, хүзүү нь гудамжны бусад бүрдэлтэй өнгө, загвар, дизайны уялдаатай, нэгдсэн хослол байх ёстой.
- 12.4 Авто замын гэрэлтүүлгийг замын өргөн ба урсгалаас хамааруулж дараах байдлаар төлөвлөж болно.
- 12.5 Орон сууц хорооллын дундах айлын цонхны эсрэг тал руу гэрлийн тусгалыг байрлуулна.




Зураг 12.1. Гэрэлтүүлгийг байрлуулах



Зураг 12.2. Явган замд гэрэлтүүлэг байрлуулах

Хүснэгт. 12.1. Гэрэлтүүлгийн өндөр болон байрлуулах зай

№	Гэрэлтүүлгийн өндөр /м/	Гэрэлтүүлэг хоорондын зай /м/	Гудамжны өргөн /м/	Натрийн чийдэн /ватт/	LED чийдэн /ватт/
1	5-6	15-20	6-7	100	30-60
2	6-8	18-24	7-10	150	60-80
3	8-10	24-30	10-12	250	100-120
4	10-13	30-39	12-15	400	150-200




Зураг 12.3. Гэрэлтүүлгийг байрлуулах өндөр




Зураг 12.4. Гэрэлтүүлгийг замын хоёр талаар байрлуулах

13. СУУРИЛУУЛАХ ТЕХНИК


- 13.1 Гудамж, зам, цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийн сүлжээ болон тэжээл нь бие даасан шугамтай хийгдсэн байвал зохино.
- 13.2 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд суурилуулж байгаа гэрэлтүүлэг нь гэрэлтүүлгийн удирдлагын самбараас удирдах боломжтой байна. Уг самбар нь цайвар саарал өнгөтэй байна. Өнгөний код нь R-205 G-210 B-215 байна.
- 13.3 Гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийн утсыг далд сувагт хийж гүйцэтгэнэ.
- 13.4 Гэрэлтүүлгийг суурилуулах суурийн хэсэглэлийг Зураг 13.1-д үзүүлэв.




Зураг 13.1. Гэрэлтүүлгийг суурилуулах /a, b, c, d, e хэмжээ нь суурилуулж байгаа гэрэлтүүлгийн шонгийн хэмжээ, өндөр, материал, техникийн шаардлага зэргээс хамаарч аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна/




Зураг 13.3. Гэрэлтүүлгийн удирдлагын самбарын суурьлуулалт ба хэмжээ



Зураг 13.5. Гэрэлтүүлгийн удирдлагын самбарын харагдах байдал /нүүр ба ар тал/



Зураг 13.2. Гэрэлтүүлгийн удирдлагын самбарын хэмжээ



Зураг 13.4. Цутгамал бетон суурь ба хэмжээ

- 13.5 Төгсгөлийн болон эргэлттэй шонд татлага хийхгүй уг хэсгийн шонд хүчитгэсэн хийцлэл хийнэ.
- 13.6 Гэрэлтүүлгийн шонг босгохдоо хөрснөөс хамаарч намагтай газар бол намгийн хамгаалалт хийнэ.
- 13.7 Шон доторх холболт гал хамгаалалтын тоноглол бүхий хайрцагтай байна.
- 13.8 Гэрэлтүүлгийн шон газрын 00 түвшинээс дээш 10 см-ээс багагүй өргөнтэй цацруулагчтай байна.
- 13.9 Эрх бүхий байгууллагаас баталсан шонгийн дугаарын загвараар дугаарласан байна.

14. АШИГЛАЛТ

- 14.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам, цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн бүртгэл, засвар үйлчилгээг төлөвлөх хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын систем” болон “Гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлагын систем” нэвтрүүлж цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд нэр төрөл тус бүрээр бүртгэх, хянах, засварлах хуваарь гаргаж хөтөлбөр боловсруулж ашиглана.
- 14.2 Гэрэлтүүлгийн төхөөрөмжийг залгах, салгах ажилбар нь жил, улирлын цаг агаар, орон нутгийн онцлогийг харгалзан баталсан график, хуваарийн дагуу автоматаар гүйцэтгэгдэж байх ёстой.
- 14.3 Гэрэлтүүлгийн ашиглалтын байдалд хяналт үнэлгээг дараах шалгах хуудасны дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 14.1. Гэрэлтүүлгийн ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх үзүүлэлт.

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Гэрэлтүүлэг анивчсан шатсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гэрэлтүүлгийн шон, бусад хийц тоног төхөөрөмжийн бүтэн байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бохирдол /тоос, шороо болон бусад бохирдол/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Ил гарсан цахилгааны утас байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Цахилгааны галын аюулгүй байдлыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Гэрэлтүүлгийн шон цацруулагчтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Шонгийн дугаарлалт хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Кабель шугамын хөндлөн огтлолын талбай хэмжээ нийцсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Гэрэлтүүлэгч заагдсан чадалдаа бүрэн хүрч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Нэгдсэн удирдлагын системд холбогдож ажиллаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

15. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг, БНБД 23-02-08;
2. Гэрэлтүүлгийн ган шон техникийн шаардлага, MNS 2568:1983;
3. Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг, БНБД 83-27-00;
4. Замын гэрэлтүүлгийн стандарт БНСУ-ын стандарт KS A 3701:2007;
5. Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм, БД 43-101-03;
6. ОХУ-ын гэрэлтүүлгийн стандарт, ГОСТ Р 55844 – 2013;
7. Хот тосгон ба суурин газрын гудамж зам талбайн гэрэлтүүлгийн стандартыг боловсруулах /УБЗАА 2019/;
8. Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх, БД 30-102-11;
9. Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм;
10. Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм;
11. Эрчим хүчний тухай хууль;